

## ЭРДЭНЭ РЕСУРС НЬ ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭГ ШИНЭЧЛЭН, БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТУХАЙ ТАНИЛЦУУЛЛАА

Хэвлэлийн мэдээ

Халифакс хот, Нова Скошиа муж

2022.10.18

**Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX:ERD; MSE:ERDN)** ("Эрдэнэ Ресурс" эсвэл "Компани") нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт орших Хөндий Алтны Дүүрэг дэх компанийн 100% эзэмшлийн Баян Хөндий Алтны Ордын хөгжүүлэлтийн хүрээнд хийгдсэн "Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ"-г (ОНХАГ) шинэчилснийг мэдээлэхэд таатай байна. Түүнээс гадна, компани байгаль орчин, нийгэм, засаглалын хөтөлбөрүүдийн тухай танилцуулав.

### Тодруулга:

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: "Эрдэнэ Ресурс нь өнгөрсөн хорин жилийн турш хайгуул болон хөгжүүлэлтийн чиглэлээр Баянхонгор аймагт төвлөрөн ажиллаж байна. Бид орон нутгийн оролцогч талуудтай үр өгөөжөө хуваалцах зорилтын хүрээнд ажилласаар ирсэн бөгөөд шинэ дүүргийг олборлолтын шат руу хөгжүүлэх явцад дээрх зорилтын хүрээнд хийгдэж буй ажлуудын үр дүн илүү тодорхой болох нь гарцаагүй. Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээг шинэчилснээр Эрдэнэ Ресурс сүүлийн 12 сарын хугацаанд хийсэн 1 сая ам.долларын (3.4 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалтаас гадна ирээдүйд 2 жилийн хугацаанд орон нутгийн хөгжлийн төслүүдэд 1.2 сая ам.долларын (4.1 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалт хийнэ. Гэрээг шинэчлэхэд хувь нэмрээ оруулсан Баянхонгор аймгийн иргэд, тэр дундаа Засаг дарга Д.Мөнхсайханд талархал илэрхийлье."

Петер Акерли үргэлжлүүлэн: "Хөндий Алтны Дүүргийн бүтээн байгуулалт нь Монголын баруун өмнөд бүсэд эдийн засгийн эерэг өөрчлөлт үзүүлэх боломжтой. Төмөр зам, авто замын өргөтгөл, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэхэд тохиромжтой нөхцөл, Баян Хөндий алтны орд, Алтан Нар полиметаллын орд, Зуун Мод зэс-молибденийн ордууд зэрэг үнэт болон суурь металлын томоохон ордуудыг нээн илрүүлсэн зэрэг хүчин зүйлүүд нь энэхүү бүс нутаг нь үндэсний хэмжээний аж үйлдвэрлэлийн бүс нутаг болох боломжтойг илэрхийлнэ."

### **Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ болон орон нутгийн хөгжил**

Эрдэнэ Ресурс нь 2024 оны 12-р сарын 31-ний өдрийг дуустал хүчин төгөлдөр мөрдөгдөх ОНХАГ-г шинэчилснийг танилцуулахад таатай байна. ОНХАГ нь Ашигт малтмалын тухай хуулийн хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын орон нутаг буюу аймаг, сумдын захиргаатай зайлшгүй гүйцэтгэх гэрээ юм. ОНХАГ-г компаниас гадна дараах оролцогч талууд хамтран баталгаажуулсан:

- Баянхонгор Аймаг: Засаг дарга Д.Мөнхсайхан
- Баян-Өндөр сум: Засаг дарга Б.Идэрмөнх
- Шинэжинст сум: Засаг дарга Б.Бат-Эрдэнэ

Баянхонгор аймаг нь 116,000 км<sup>2</sup> буюу газар нутгийн хэмжээгээр Монгол Улсдаа дөрөвт жагсах аймаг юм. Эрдэнэ Ресурсийн төслүүд нь Баян-Өндөр, Шинэжинст сумын нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд Баян Хөндий Алтны Төсөл сумын төвүүдээс 110 км, 90 км зайтай оршдог. Баянхонгор аймаг нь Монгол Улсын хүн амын нягтаршил хамгийн бага аймгуудын нэг бөгөөд Баян-Өндөр, Шинэжинст сумдад нийт 5000 орчим иргэн оршин суудаг. Баян Хөндий төслийн талбайн ойр орчимд байнгын оршин суугч байхгүй бөгөөд төслөөс 10 км зайд 10 орчим өрхийн мал бэлчиж байсан түүхтэй.

Манай үйл ажиллагаагаа эрхлэн явуулдаг орон нутгийн алслагдмал нөхцөл байдлын онцлогоос хамаарч бид эрүүл мэнд, дэд бүтцийн салбаруудыг онцлон авч үздэг ба ОНХАГ-ний хөрөнгө оруулалт дээрх салбаруудад төвлөрсөөр ирсэн.

Шинэчилсэн ОНХАГ нь 2021 оны 7-р сард байгуулсан гэрээнд үндэслэсэн бөгөөд Монгол Улсын баруун өмнөд бүс нутгийг хөгжүүлэхэд Компани болон орон нутгийн засаг захиргаа хамтран ажиллана. Эрдэнэ Ресурс өнөөг хүртэл төсөл хөтөлбөрүүдэд 1 сая ам.долларын (3.4 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд шинэчлэгдсэн ОНХАГ-ний хүрээнд үргэлжлүүлэн 1.2 сая ам.долларын (4.1 тэрбум төгрөг) хөрөнгө оруулалт хийнэ. ОНХАГ-ний санхүүжилтийн 60 орчим хувийг аймгийн төсөл хөтөлбөрүүд, үлдсэн 40 орчим хувийг хоёр сумдын хөтөлбөрүүдэд зарцуулна. ОНХАГ-г Эрдэнэ Ресурсийн төлөөлөгч болон орон нутгийн сонгогчдын төлөөллүүдээр ахлуулсан ашгийн бус байгууллага удирддаг. Ингэснээр ОНХАГ-ний хүрээнд санхүүжүүлэх төсөл хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авах, сонгон шалгаруулах, баталгаажуулах болон цаашдаа хэрэгжсэн төсөл хөтөлбөрүүдийн гүйцэтгэлийг үнэлнэ.

Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд цар тахлын нөлөөллөөс үүдэн ОНХАГ-ний санхүүжилтийн 32% нь нийгмийн эрүүл мэндэд чиглэсэн хөрөнгө оруулалтууд байв. Эрдэнэ Ресурсийн дэмжлэгээр шинжилгээ, оношилгооны тоног төхөөрөмж, эмнэлгийн ажилтнууд, сайн дурын ажилтнуудад зориулсан хувийн хамгаалах хэрэгслүүдийг санхүүжүүлж, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах эмчилгээ, эмний нийлүүлэлтийг хүртээмжтэй болгосон. Түүнээс гадна компани нь аймаг, сумдын сэтгэцийн эрүүл мэнд, бие бялдрын чийрэгжүүлэлтийн сургалтуудыг дэмжин ажилласан.

Компани нь өнгөрсөн нэг жилийн хугацаанд орон нутгийн дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүд, орон нутгийн амьжиргааг дээшлүүлэх хөтөлбөрүүдэд 450,000 ам.долларын санхүүжилт хийсэн. Аймгийн төвийн цэцэрлэгт хүрээлэнг нөхөн сэргээх, төвлөрсөн дулааны станцад агаарын чанарыг сайжруулах төхөөрөмж суурилуулах, цаг агаарын хүндрэлтэй нөхцөлд малын тэжээлээр хангах зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн.

Үлдсэн 20%-ийн санхүүжилт нь залуучуудын хөгжил, олон нийтийн боловсролд зориулагдсан. Төсөл хөтөлбөрүүдээс онцолбол: орон нутгийн сургуулиудыг цар тахлын үед зайнаас суралцах боломжтой болгон тоног төхөөрөмжөөр хангаж,

сургалтуудыг хийсэн. Түүнээс гадна оролцогч талуудын соёл урлаг, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх ажлын хүрээнд тэмдэглэлт өдрүүд, спортын арга хэмжээнүүдийг дэмжин ажилласан.

Бид ОНХАГ-ний хүрээнд санхүүжилт хийхээс гадна орон нутгийн оролцогч талуудтай бизнесийн хамтын ажиллагаагаа өргөжүүлсээр байна. Баян Хөндий төслийн бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрүүд багтсан бөгөөд эхний ээлжид барилга угсралт, байгаль орчны нөхөн сэргээлтэд онцлон анхаарч байна. 100 гаруй орон нутгийн иргэдийг ажлын байрны чиглэл олгох сургалт болон мэргэжлийн сургалтад хамруулж, 2022 онд 30 гаруй иргэдийг ажлын байраар хангасан. Баян Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу хөгжүүлэх хэрээр компани нь орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах зорилтыг эн тэргүүнд тавих болно.

Баян Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу хөгжүүлснээр аймгийн хүрээнд хамгийн том татвар төлөгч болох тооцоололтой байна. Улсын хэмжээнд, төсвийн орлогын дөрөвний нэгийг эрдэс баялгийн салбараас бүрдүүлдэг.

### **Байгаль орчин**

Компани нь Монгол Улсын хууль, дүрэм журмын хүрээнд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (“БОНБНУ”) болон Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ (“БОННУ”)-д тусгагдсан байгаль орчны менежментийн голлох элементүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлсээр байна. БОННУ-тай англи, монгол хэл дээр компанийн вэбсайтаас танилцах боломжтой.

Эрдэнэ Ресурс нь бизнесийн үйл ажиллагаа явуулахын өмнө гарч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, зайлшгүй гарах нөлөөллийг бууруулах замаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгахаар ажилладаг. Байгаль орчны менежментийн хэмжүүрүүд нь байнгын хяналтын зарчмаар ашиглагддаг нь төслийн ашиглалтын хугацаанд хувьсан өөрчлөгддөг. Боломжит нөлөөллийг ус, хаягдал, ландшафт, эрчим хүч гэх мэт олон хүчин зүйлээр хэмждэг.

Эрдэнэ Ресурс 2022 оны 3-р улиралд усны нөөцийг иргэдийн оролцоотой хянах байгаль орчны хяналтын хөтөлбөрийг санаачилсан. Орон нутгийн иргэд компанийн ажилтнуудтай хамт төслийн талбай болон сумын ойр орчмын нутаг дэвсгэрт сонгосон цэгүүдийн усны түвшинг шалгах боломжтой болсон. Түүнээс гадна, Компани нь одоо байгаа усны эх үүсвэрийг сэргээн засварлах замаар орон нутгийн айл өрхүүдийн усны хүртээмжийг сайжруулах ажлуудыг гүйцэтгэж байна.

Одоогийн байдлаар төслийн талбай дахь хог хаягдлын удирдлага нь компанийн 150 орчим хүний багтаамжтай хотхоноос үүссэн ахуйн хог хаягдлыг бууруулах, дахин боловсруулах ажлуудад чиглэж байна. Баян Хөндий төслийн ТЭЗҮ, БОНБНУ, БОННУ-нд дурдсанчлан Эрдэнэ Ресурс нь хаягдал чулуулгийг Нэгдсэн хаягдлын байгууламж (“НХБ”)-р зохицуулахаар төлөвлөж байна. НХБ-д уурхайн хаягдал чулуулгийг үйлдвэрээс гарах хуурай хаягдалтай байршуулснаар ашиглалтын болон хаалтын үеийн байгаль орчны эрсдэлийг бууруулж, төслийн нийт газрын эвдрэлийг багасгах ач холбогдолтой. НХБ-ыг Монгол Улсад анх удаа хэрэгжүүлж байгаа бөгөөд нарийвчилсан зураг төслийн зөвшөөрлүүдийг бүрэн авсан.

Мөн Эрдэнэ Ресурс нь төслийн эрчим хүчний шаардлагууд, техникийн судалгаа, үнэлгээг үргэлжлүүлэн хийсээр байна. Уламжлалт болон сэргээгдэх эх үүсвэрээс бүрдэх хосолсон эрчим хүчний эх үүсвэрийн судалгааг энэ оны эхэнд баталснаар эрчим хүчний үр ашгийг нэмэгдүүлсэн. Уурхайн эрчим хүчний 20 гаруй хувийг сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангах төлөвлөгөөтэй байна.

Ашигт малтмалын хайгуул, олборлолтын үйл ажиллагааны үеэр газрын түр хугацааны эвдрэл үүсдэг. Компани нь сөрөг нөлөөллийг багасгах, өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд мэдэгдэж буй бүх болзошгүй эвдрэлийг үнэлж, төлөвлөх журмуудыг дагаж мөрддөг. Түүнээс гадна Эрдэнэ Ресурс нь төслийн талбайд болон талбайн гаднах биологийн олон янз байдлыг сэргээх, хамгаалах нэмэлт үйл ажиллагаа явуулдаг.

Компани нь Баян Хөндий төслийн талбайд өргөтгөсөн 2 га ургамалжуулалтын талбай байгуулж эхний үе шатыг дуусгалаа. Бид Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг дэмжин 1 сая мод тарих амлалтынхаа хүрээнд 10 мянган мод, үрсэлгээг тарьж туршсан.

Монгол Улсын байгаль орчныг хамгаалах дүрмүүдэд уул уурхайн бүх төслүүд биологийн олон янз байдлыг нөхөн сэргээх тооцоолол төлөвлөгөө, хэрэгжүүлэлтийг тусгасан байдаг. Эрдэнэ Ресурсийн төслүүдийн олборлолтын үйл ажиллагаа хараахан эхлээгүй байгаа ч компани нь төслийн талбайгаас 170 км орчим зайд орших, Их Богдын тусгай хамгаалалтын захиргаа дахь цэцэрлэгт хүрээлэнгийн бүсэд орших хууль бус алт олборлолтод өртөж эвдэрсэн 14 га орчим талбайг сэргээн засварлахад дэмжлэг үзүүлсэн.

Компани нь 2022 оны эцэст байгаль орчны менежментийн хөтөлбөрүүдийг өмнөх жилүүдээс өргөтгөх төлөвлөгөөгөө биелүүлснээр Баян Хөндий төслийг хөгжүүлэхэд чухал хүчин зүйл болно.

### **Компанийн Засаглал**

Компанийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр компани нь ёс зүйтэй, хариуцлагатай ажиллах соёлыг чухалчлах болно. Манай баг оролцогч талуудтай харилцаа холбоо тогтоож, нийгэмд эерэг хувь нэмэр оруулахын төлөө ажилладаг.

ТУЗ-ийн гишүүд, удирдлагын баг болон бүх ажилтнууд жил бүр сургалтад хамрагдаж, компани, бизнесийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгож байна. Түүнээс гадна, Эрдэнэ Ресурсийн ТУЗ нь Компанийн засаглалын хороотой бөгөөд тус хороо нь Анна Биолик (Канад Улсаас Монгол Улсад суусан анхны Элчин сайд), Лэйтон Крофт (Монгол Улсад 25 жил ажилласан туршлагатай уул уурхайн салбарын мэргэжилтэн), Жон Бюрн (ТУЗ-д хамгийн урт хугацаанд ажиллаж буй хараат бус гишүүн) зэрэг гурван хараат бус ТУЗ-ийн гишүүдээс бүрдсэн. Компанийн засаглалын хороо нь байгууллагын шударга, ил тод байх орчныг бүрдүүлэхэд чиглэж ажилладаг. Компани нь ил тод байдлыг хангах ажлыг өргөжүүлэн, Канадын Засгийн газрын Шударга байдлын тухай тунхаг бичигт гарын үсэг зурсан.

Эрдэнэ Ресурсийг Монгол Улсын Засгийн газар болон салбарын холбоод сүүлийн хорин жилийн турш тэргүүлэх хамтрагч хэмээн үнэлсээр ирсэн. Гүйцэтгэх захирал Петер Акерлиг улс орны хөгжилд оруулсан хувь нэмрийг нь үнэлэн, төрийн дээд

шагнал Алтан Гадас одонгоор шагнасан. Түүнээс гадна компани нь Монгол Улсын уул уурхайн салбарын хөгжилд оруулсан хувь нэмрээ үнэлүүлж, бусад шагнал урамшууллууд хүртэж байв.

Эрдэнэ Ресурс нь Монголын хөрөнгийн бирж (“МХБ”)-д давхар бүртгүүлсэн анхны бөгөөд одоогоор цорын ганц компани юм. МХБ-д давхар бүртгэл хийлгэснээр Монголын хөрөнгө оруулагчид компанийн хувьцааг худалдаж авах боломжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх хосолсон үр нөлөөтэй. Монголын 5000 орчим хөрөнгө оруулагчид компанийн хувьцааг эзэмшдэг бөгөөд олон нийтэд мэдээлэх бүх баримт бичгүүдийг англи, монгол хэлээр боловсруулан, танилцуулдаг.

### **Эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа**

Компани аюулгүй ажиллагааг байгууллагын төдийгүй хувь хүний үүрэг гэж үздэг. Эрдэнэ Ресурс нь 2022 онд бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын хүрээнд аюул эрсдэл тодорхойлох хөтөлбөрийг нэвтрүүлж, ажлын байрны аюулгүй байдлыг хангах урьдчилан сэргийлэх арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлсэн. Компани нь 2022 онд хугацаа алдсан гэмтлийн (“LTI”) тохиолдолгүй хэвээр ажиллаж байна. Компани нь ирээдүйн уурхайн бүтээн байгуулалтаас өмнө Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны удирдлагын зохицуулалтын тогтолцоог боловсруулна.

### **Тогтвортой хөгжил**

Байгаль орчин, нийгэм, засаглалын гүйцэтгэл нь дэлхийн жишигт нийцсэн төслүүдийг хөгжүүлэхдээ бүх оролцогч талуудад үнэ цэнийг бий болгох зорилтын хүрээнд ажиллаж буй Эрдэнэ Ресурсийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Бид оролцогч талуудтай харилцаа тогтоох, сайжруулахад чухал ач холбогдол өгч ажилладаг. Эрдэнэ Ресурс нь 2017 оноос хойш Бритиш Колумбын Их Сургууль (“UBC”)-тай орон нутгийн иргэдийн оролцоо, оролцогч талуудын хамтын ажиллагааны чиглэлээр судалгаа хийсэн. Бритиш Колумбын Их Сургуультай хамтран хийсэн энэхүү судалгаа нь академик сэтгүүлүүдэд нийтлэгдсэн ба хамгийн сүүлд “Бизнесийн стратеги ба хөгжил” сэтгүүлийн 2022 оны 9 дүгээр сарын дугаарт нийтлэгдсэн.

### **Компанийн тухай**

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд 1 хайгуулын, 3 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт [www.erdene.com](http://www.erdene.com)-оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

## Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

*Орчуулга: Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.*

**ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.**

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал  
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

И-мэйл: [info@erdene.com](mailto:info@erdene.com)

Twitter: <https://twitter.com/ErdeneRes>

Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>

LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp-/>